**"БЭСТ ФОРТУНА АУДИТ" ХХК**
Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 2-р хороо
"Урбанек" ХХК-ийн байр 306, 307 тоот
Утас: 324338, 89116465, 98056465, 99095580
И-мэйл: fortune2009audit@gmail.com

2025. 04. 22 № 71

танай ______________-ны №______________-т

**"МОНГОЛ НЭХМЭЛ" ХК-ИЙН
ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ
С.МАНДУХАЙ ТАНАА**

## АУДИТОРЫН ДҮГНЭЛТ

**Бид "Монгол нэхмэл" ХК-ийн 2024 оны 12 сарын 31-нээрх Санхүүгийн байдлын тайлан, энэ өдрөөр тасалбар болсон Орлогын дэлгэрэнгүй, Өмчийн өөрчлөлт, Мөнгөн гүйлгээний тайлангууд болон эдгээр тайлантай холбоотой нэмэлт тайлбар тодруулга болон Нягтлан бодох бүртгэлийн бодлогуудад аудит хийж гүйцэтгэлээ.**

**Бидний дүгнэлтээр Санхүүгийн тайлангуудыг бэлтгэхдээ СТОУС, түүнд нийцүүлэн гаргасан Монгол Улсын Сангийн сайдын тушаалаар батлагдсан нягтлан бодох бүртгэл, тайлагналтай холбоотой журам, зааврын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, бодитойгоор илэрхийлсэн байна.**

***Дүгнэлтийн үндэслэл***

**Аудитын явцад нягтлан бодох бүртгэлийн хувьд баримталсан зарчим, сонгож хэрэглэсэн арга, дотоод хяналтын системийг судлав. Санхүүгийн тайлангууд нь материаллаг алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэл бүхий нотолгоо олж авах зорилгоор аудитын түүврийн болон бусад арга горимуудыг гүйцэтгэсэн бөгөөд бидний гүйцэтгэсэн аудит нь аудитын дүгнэлт гаргахад хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоогоор хангагдсан гэж итгэж байна.**

***Аудитын гол асуудал***

**Аудитын гол асуудал гэдэг нь аудиторын мэргэжлийн шийдлийн хүрээнд тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлсэн асуудлууд байдаг. Эдгээр асуудлыг бид санхүүгийн тайлангийн аудитын агуулгын хүрээнд бүхэлд нь болон энэ тайлангийн талаар аудиторын дүгнэлт гаргахад авч үзсэн бөгөөд аудитор эдгээр асуудлаар тусад нь дүгнэлт өгдөггүй.**

***Бусад мэдээлэл***

**Удирдлага нь бусад мэдээллийн хувьд үүрэг, хариуцлага хүлээнэ. Бусад мэдээлэл гэдэгт санхүүгийн тайланд орсон мэдээллийг хамруулж ойлгох ба санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт нь бусад мэдээллийг хамрахгүй бөгөөд үүнд бид ямар нэгэн баталгаажуулалт илэрхийлэхгүй.**

***Санхүүгийн тайлангийн талаар удирдлагын болон засаглал хариуцсан этгээдүүдийн хүлээх үүрэг хариуцлага***

Удирдлага нь Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн дагуу эдгээр санхүүгийн тайланг бэлтгэх, үнэн зөв толилуулах хариуцлага хүлээх бөгөөд мөн залилан юмуу алдаанаас үүдэлтэй материаллаг алдаа зөрчилгүй бэлтгэж, нягтлан бодох бүртгэлийн тохиромжтой бодлогуудыг сонгож хэрэглэх, шударгаар толилуулахтай холбоотой, зайлшгүй чухал гэж өөрийн тодорхойлсон дотоод хяналтуудын талаарх хариуцлагыг хүлээнэ. Засаглал хариуцсан этгээдүүд санхүүгийн тайлагналын үйл явцыг хянах үүрэгтэй.

***Аудиторын хүлээх үүрэг хариуцлага***

Бидний зорилго бол ёс зүйн шаардлагуудыг дагаж мөрдөн, санхүүгийн тайлангууд бүхэлдээ аливаа залилан эсвэл алдаанаас үүдэлтэй материаллаг хэмжээний буруу илэрхийлэлгүй эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах болон бидний дүгнэлтийг багтаасан аудиторын тайлан бэлтгэх юм. Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь өндөр түвшний баталгаажуулалт боловч Аудитын олон улсын стандартын дагуу гүйцэтгэгдсэн аудитаар оршин байгаа материаллаг буруу илэрхийллийг үргэлж илрүүлнэ гэсэн баталгаа өгдөггүй. Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас гарах бөгөөд хэрэв тэдгээр нь дангаараа болон нийлбэр дүнгээрээ санхүүгийн тайлангуудад үндэслэн хэрэглэгчдийн гаргах эдийн засгийн шийдвэрт мэдэгдэхүйц нөлөөлөх бол материаллаг гэж үзнэ,

ЗАХИРАЛ Ж. ОЮУНЦЭЦЭГ

**"МОНГОЛ НЭХМЭЛ " ХК**

**2024 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31-НИЙ ӨДРӨӨРХ**
**АУДИТЛАГДСАН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН**

*(төгрөг)*

| Үзүүлэлтүүд | 2024-12-31 | |
|---|---|---|
| | Аудитлагдаагүй | Аудитлагдсан |
| **ХӨРӨНГӨ** | | |
| **Эргэлтийн хөрөнгө** | | |
| Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө | 36,494,007.25 | 36,494,007.25 |
| Дансны авлага | 348,329,877.83 | 348,329,877.83 |
| Бараа материал | 329,126,668.42 | 329,126,668.42 |
| Урьдчилж төлсөн зардал/тооцоо | 321,380,902.59 | 321,380,902.59 |
| ***Эргэлтийн хөрөнгийн дүн*** | **1,035,331,456.09** | **1,035,331,456.09** |
| **Эргэлтийн бус хөрөнгө** | | |
| Үндсэн хөрөнгө | 3,854,241,217.32 | 3,854,241,217.32 |
| Биет бус хөрөнгө | 20,169,350.96 | 20,169,350.96 |
| ***Эргэлтийн бус хөрөнгийн дүн*** | **3,874,410,568.28** | **3,874,410,568.28** |
| **Нийт хөрөнгийн дүн** | **4,909,742,024.37** | **4,909,742,024.37** |
| **ӨР ТӨЛБӨР БА ЭЗЭМШИГЧИЙН ӨМЧ** | | |
| **Өр төлбөр** | | |
| **Богино хугацаат өр төлбөр** | | |
| Дансны өглөг | 276,149,149.90 | 276,149,149.90 |
| Цалингийн өглөг | 7,543,305.00 | 7,543,305.00 |
| Татварын өр | 175,117,713.18 | 175,117,713.18 |
| НДШ-ийн өглөг | 5,042,811.04 | 5,042,811.04 |
| Богино хугацаат зээл | - | - |
| Хүүний өглөг | - | - |
| Урьдчилж орсон орлого | 58,979,933.68 | 58,979,933.68 |
| Бусад богино хугацаат өр төлбөр | - | - |
| ***Богино хугацаат өр төлбөрийн дүн*** | **522,832,912.80** | **522,832,912.80** |
| Урт хугацаат зээл | 728,750,000.00 | 728,750,000.00 |
| Бусад урт хугацаат өр төлбөр | | - |
| ***Урт хугацаат өр төлбөрийн дүн*** | **728,750,000.00** | **728,750,000.00** |
| **Өр төлбөрийн нийт дүн** | **1,251,582,912.80** | **1,251,582,912.80** |
| **Эзэмшигчийн өмч** | | |
| Өмч: а) Төрийн | | - |
| б) Хувийн | - | - |
| в) Хувьцаат | 113,358,907.00 | 113,358,907.00 |
| Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл | 2,709,470,415.62 | 2,709,470,415.62 |
| Эздийн өмчийн бусад хэсэг | 79,080,900.00 | 79,080,900.00 |
| Хуримтлагдсан ашиг (алдагдал) | 756,248,888.95 | 756,248,888.95 |
| ***Эзэмшигчийн өмчийн дүн*** | **3,658,159,111.57** | **3,658,159,111.57** |
| **Өр төлбөр ба эзэмшигчийн өмчийн дүн** | **4,909,742,024.37** | **4,909,742,024.37** |

"МОНГОЛ НЭХМЭЛ " ХК

## 2024 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31-НИЙ ӨДРӨӨР ДУУСГАВАР БОЛСОН АУДИТЛАГДСАН ОРЛОГЫН ДЭЛГЭРЭНГҮЙ ТАЙЛАН

(төгрөг)

| Үзүүлэлтүүд | 2024-12-31 | |
|---|---|---|
| | Аудитлагдаагүй | Аудитлагдсан |
| Борлуулалтын орлого | 8,638,676.16 | 8,638,676.16 |
| Борлуулсан бүтээгдэхүүний өртөг | - | - |
| **Нийт ашиг (алдагдал)** | **8,638,676.16** | **8,638,676.16** |
| ***Үйл ажиллагааны зардал*** | | |
| Түрээсийн орлого | 1,821,733,423.18 | 1,821,733,423.18 |
| Хүүгийн орлого | - | - |
| Ноогдол ашгийн орлого | - | - |
| Эрхийн шимтгэлийн орлого | - | - |
| Бусад орлого | - | - |
| Борлуулалт маркетингийн зардал | 38,687,951.64 | 38,687,951.64 |
| Ерөнхий ба удирдлагын зардал | 1,429,842,610.69 | 1,429,842,610.69 |
| Санхүүгийн зардал | 90,325,202.62 | 90,325,202.62 |
| Бусад зардал | 59,545,639.22 | 59,545,639.22 |
| Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз) | - | - |
| Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз) | - | - |
| Биет бус хөрөнгө данснаас хассаны олз (гарз) | - | - |
| Хөрөнгө оруулалт борлуулснаас үүссэн олз (гарз) | - | - |
| Бусад ашиг (алдагдал) | - | - |
| **Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)** | **211,970,695.17** | **211,970,695.17** |
| Орлогын татварын зардал | 24,172,820.93 | 24,172,820.93 |
| **Татварын дараах ашиг (алдагдал)** | **187,797,874.24** | **187,797,874.24** |
| **Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)** | - | - |
| **Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)** | **187,797,874.24** | **187,797,874.24** |
| **Бусад дэлгэрэнгүй орлого** | - | - |
| Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн зөрүү | - | - |
| Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү | | - |
| Бусад олз (гарз) | - | - |
| **Орлогын нийт дүн** | **187,797,874.24** | **187,797,874.24** |
| **Нэгж хувьцаанд ноогдох суурь ашиг (алдагдал)** | - | - |

БЭСТ ФОРТУНА АУДИТ ХХК

"МОНГОЛ НЭХМЭЛ " ХК

## 2024 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31-НИЙ ӨДРӨӨР ДУУСГАВАР БОЛСОН ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН АУДИТЛАГДСАН ТАЙЛАН

(төгрөг)

| Үзүүлэлт | Өмч | Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл | Эздийн өмчийн бусад хэсэг | Хуримтлагдсан ашиг | Нийт дүн |
|---|---|---|---|---|---|
| **2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **113,358,907.00** | **-** | **79,080,900.00** | **605,430,137.78** | **797,869,944.78** |
| Бүртгэлийн бодлогын өөрчлөлт | | | - | | |
| Залруулсан үлдэгдэл | 113,358,907.00 | - | 79,080,900.00 | 605,430,137.78 | 797,869,944.78 |
| Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал) | - | | - | (36,979,123.07) | (36,979,123.07) |
| Бусад дэлгэрэнгүй орлого | | | | | - |
| Өмчид гарсан өөрчлөлт | - | 3,119,548,180.00 | - | | 3,119,548,180.00 |
| Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн | | - | | | - |
| **2023 оны 12-р сарын 31-нээрх** | **113,358,907.00** | **3,119,548,180.00** | **79,080,900.00** | **568,451,014.71** | **3,880,439,001.71** |
| Бүртгэлийн бодлогын өөрчлөлт | | | | | - |
| Залруулсан үлдэгдэл | 113,358,907.00 | 3,119,548,180.00 | 79,080,900.00 | 568,451,014.71 | 3,880,439,001.71 |
| Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал) | - | | - | 187,797,874.24 | 187,797,874.24 |
| Бусад дэлгэрэнгүй орлого | - | | | - | |
| Өмчид гарсан өөрчлөлт | - | (410,077,764.38) | - | - | (410,077,764.38) |
| Дахин үнэлгээний нэмэгдлийн хэрэгжсэн дүн | - | | | - | |
| **2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **113,358,907.00** | **2,709,470,415.62** | **79,080,900.00** | **756,248,888.95** | **3,658,159,111.57** |

"МОНГОЛ НЭХМЭЛ " ХК

## 2024 ОНЫ 12 ДУГААР САРЫН 31-НИЙ ӨДРӨӨР ДУУСГАВАР БОЛСОН ЖИЛИЙН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ АУДИТЛАГДСАН ТАЙЛАН

(төгрөг)

| Үзүүлэлтүүд | 2024-12-31 | |
|---|---|---|
| | Аудитлагдаагүй | Аудитлагдсан |
| **Үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ** | | |
| ***Мөнгөн орлогын дүн (+)*** | **1,990,081,539.24** | **1,990,081,539.24** |
| Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсний орлого | 1,980,578,995.53 | 1,980,578,995.53 |
| Эрхийн шимтгэл, хураамж, төлбөрийн орлого | - | |
| Буцаан авсан албан татвар | | - |
| Бусад мөнгөн орлого | 9,502,543.71 | 9,502,543.71 |
| ***Мөнгөн зарлагын дүн (-)*** | **1,298,585,631.03** | **1,298,585,631.03** |
| Ажиллагсдад олгосон мөнгө | 227,567,361.16 | 227,567,361.16 |
| Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн | 62,375,799.94 | 62,375,799.94 |
| Бараа, материал худалдан авахад төлсөн | 57,463,176.87 | 57,463,176.87 |
| Түлш шатахуун, тээврийн хөлс, сэлбэгт төлсөн | 15,338,350.00 | 15,338,350.00 |
| Ашиглалтын зардалд төлсөн | 649,880,233.31 | 649,880,233.31 |
| Хүүний төлбөрт төлсөн | 90,325,202.62 | 90,325,202.62 |
| Татварын байгууллагад төлсөн | 121,583,335.37 | 121,583,335.37 |
| Даатгалын төлбөрт төлсөн | - | - |
| Бусад мөнгөн зарлага | 74,052,171.76 | 74,052,171.76 |
| ***Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ*** | **691,495,908.21** | **691,495,908.21** |
| ***Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ*** | | |
| ***Мөнгөн орлогын дүн (+)*** | **635,810,632.00** | **635,810,632.00** |
| Үндсэн хөрөнгө борлуулсаны орлого | - | |
| Бусдад олгосон зээл, мөнгөн урьдчилгааны буцаан төлөлт | 635,810,632.00 | 635,810,632.00 |
| Хүлээн авсан хүүний орлого | | - |
| ***Мөнгөн зарлагын дүн (-)*** | **645,902,037.11** | **645,902,037.11** |
| Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн | 599,990.00 | 599,990.00 |
| Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн | | - |
| Бусдад олгосон зээл болон урьдчилгаа | 645,302,047.11 | |
| Бусад мөнгөн зарлага | | |
| ***Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ*** | **(10,091,405.11)** | **(10,091,405.11)** |
| **Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ** | | |
| ***Мөнгөн орлогын дүн (+)*** | **50,000,000.00** | **50,000,000.00** |
| Зээл авсан, өрийн үнэт цаас гаргаснаас хүлээн авсан | 50,000,000.00 | 50,000,000.00 |
| Валютын ханшийн тэгшитгэлийн ашиг | - | - |
| Бусад мөнгөн орлого | - | |
| ***Мөнгөн зарлагын дүн (-)*** | **670,881,591.28** | **670,881,591.28** |
| Зээл, өрийн үнэт цаасны төлбөрт төлсөн | 670,881,591.28 | 670,881,591.28 |
| Санхүүгийн түрээсийн өглөгт төлсөн мөнгө | | |
| Хувьцаа буцаан худалдаж авахад төлсөн мөнгө | | |
| Валютын ханшийн тэгшитгэлийн алдагдал | - | - |
| Бусад мөнгөн зарлага | | |
| ***Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ*** | **(620,881,591.28)** | **(620,881,591.28)** |
| **Валютын ханшийн зөрүү** | **(26,588,600.65)** | **(26,588,600.65)** |
| **Бүх цэвэр мөнгөн гүйлгээ** | **33,934,311.17** | **33,934,311.17** |
| **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | **2,559,696.08** | **2,559,696.08** |
| **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | **36,494,007.25** | **36,494,007.25** |

БЭСТ ФОРТУНА АУДИТ ХХБ

## АУДИТЫН ДҮГНЭЛТИЙН ТОДРУУЛГА

"Монгол нэхмэл" ХК-нь анх 1934 онд "Эсгий цэмбэний фабрик" нэртэйгээр үйл ажиллагаа явуулж эхэлсэн бөгөөд 1959 оноос Ноосон нэхмэлийн үйлдвэр болон өргөжиж, 1992 оноос "Монгол нэхмэл" хувьцаат компани болон зохион байгуулагдаж, нарийн бүдүүн ноос будах, утас ээрэх, нэхэх, гүйцээн боловсруулах үндсэн цехүүд, лаборатори бүхий ноос, ноолууран ээрмэл, нэхмэл, сүлжмэлийн бүрэн шат дамжлагат үйлдвэрлэлийг өнөөг хүртэл явуулж байна. "Монгол нэхмэл" ХК нь 2018 оноос техник, технологийн шинэчлэлийг хийж ээрэх шугамыг өргөтгөж 75000 кг ээрмэл утас үйдвэрлэх хүчин чадалтай болж өргөжсөн.

"Монгол нэхмэл" хувьцаат компани нь нэг бүр нь 239.07 төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий 474,164 ширхэг энгийн хувьцаанаас бүрдэх дүрмийн сантай, хувьцааны 82.1 хувийг 3 хувьцаа эзэмшигч эзэмшиж байна.

"Монгол нэхмэл" ХК-ийн 2024 оны санхүүгийн тайлангуудыг Монгол Улсын Аудитын тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Аудитын Олон Улсын стандарт /АОУС/, Сангийн Яам, Санхүүгийн Зохицуулах хорооны холбогдох журам, шийдвэрүүдийн хүрээнд шалгаж танилцлаа.

Аудитлагдсан санхүүгийн тайлан нь зөвхөн 2024 оны жилийн эцсийн хөрөнгө, санхүүгийн байдал, үйл ажиллагааны үр дүнг тусган үзүүлж байгаа болно.

Байгууллагын удирдлагаас санхүүгийн тайланг тасралтгүй байх зарчимд үндэслэн бэлтгэж, орлого ба зардлыг аккруэль суурьт зарчмаар хүлээн зөвшөөрсөн.

"Монгол нэхмэл" ХК нь нягтлан бодох бүртгэл хөтөлж санхүүгийн тайлан гаргахдаа удирдлагын зардал, авлага, өглөгтэй холбоотой алдаа, зөрчлийг эс тооцвол Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Компанийн тухай хууль, Сангийн яамнаас гаргасан заавар, журмуудыг баримталж байна.

### 5. Мөнгөн хөрөнгө

Байгууллагын мөнгөн хөрөнгө нь касс дахь бэлэн мөнгө, харилцах данснаас бүрдсэн ба мөнгөн хөрөнгүүдийг валютын төрөл, зориулалт, байршлаар ангилан, нэрлэсэн үнээр үнэлж тэнцэлд тусгасан байна. Бид мөнгөн хөрөнгийн дансуудын тайлант оны гүйлгээ ба үлдэгдлийг аудитын түүврийн ба тулган баталгаажуулалтын аргаар тестлэн шалгаж дараах мэдээллийг олж тогтоов. Үүнд:

**a) Касс дахь бэлэн мөнгө**

*(мянган төгрөгөөр)*

| Төрөл | Валют | 2023.12.31 | 2024.12.31 | Өөрчлөлт |
|---|---|---|---|---|
| Бэлэн мөнгө | төгрөг | 1,041.1 | 1,492.4 | 451.3 |
| **Бэлэн мөнгөний дүн** | | **1,041.1** | **1,492.4** | **451.3** |

**b) Банкин дахь харилцах данс**

*(мянган төгрөгөөр)*

| Д/д | Харилцагч банк | Валют | Дансны дугаар | 2023/12/31 | 2024/12/31 | Өөрчлөлт |
|---|---|---|---|---|---|---|
| 1 | ХААН банкин дахь харилцах | ₮ | 5022036264 | 37.0 | 9,097.2 | 9,060.2 |
| 2 | ХААН банкин дахь карт | ₮ | 5622835449 | 5.8 | 18.0 | 12.2 |
| 3 | ХААН банкин дахь цалингийн харилцах | ₮ | 5059810761 | 0.1 | 66.4 | 66.3 |

| | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|
| 4 | Голомт банкин дахь харилцах | ₮ | 1105103124 | 1,101.5 | 25,640.2 | 24,538.7 |
| 5 | ХХБанкин дахь харилцах | ₮ | 427031521 | 68.5 | - | (68.5) |
| 6 | Хас банкин дахь харилцах | ₮ | 5000232576 | 47.4 | - | (47.4) |
| 7 | ХХБанкин дахь харилцах | $ | | 75.9 | | - |
| | | | | 0.02 | | - |
| 8 | Голомт банкин дахь харилцах | $ | 1105103125 | 182.3 | 179.8 | (2.5) |
| | | | | 0.05 | 52.09 | 52.04 |
| | **Банкин дахь харилцахын дүн** | | | **1,518.6** | **35,001.6** | **33,559.0** |

Тайлант оны эцэст мөнгөн хөрөнгийн үлдэгдэл 34,010.2 мянган төгрөгөөр өссөн байна.

## 2. Авлага

Авлагыг харилцан хамаарал бүхий компаниас авах дансны авлага, ажилчдаас авах авлага, татварын авлага гэж ангилан нэрлэсэн үнээр, харилцагчаар ангилан бүртгэлд тусгасан ба авлагуудын тооцоолол, хүлээн зөвшөөрөлт ба үнэлгээ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, стандарт, заавар аргачлалын зарчимд нийцэж байна. Мэдээллийг ашиглан дараах мэдээллийг бэлтгэв.

*(мянган төгрөгөөр)*

| Д/д | Авлагын ангилал | 2023.12.31 | 2024.12.31 | Өөрчлөлт |
|---|---|---|---|---|
| 1 | Дансны авлага Эм И Саб | 1,092,479.2 | 343,867.6 | 748,611.6) |
| 2 | Дансны авлага Монгол текстайл | 119,951.7 | - | (119,951.7) |
| 3 | Дансны авлага Шима Книттинг | 108,142.6 | | (108,142.6) |
| 4 | Дансны авлага Кашемир | | 4,462.3 | 4,462.3 |
| | **Авлагын дүн** | **1,320,573.5** | **348,329.9** | **(972,243.6)** |

Тайлант оны эцэст авлага өмнөх оноос 972,243.6 мянган төгрөгөөр буурсан нь ТУЗ-ийн 2024 оны 11 дүгээр сарын 20-ны өдрийн 03 дугаар тогтоолоор ТУЗ-ийн дарга, гүйцэтгэх захирал нарын харилцан хамааралтай тал болох Эм И Саб ХХК-с авах авлагаас захиралд өгөх 748,611.6 мянган төгрөгийг суутган тооцох шийдвэр гаргаснаас голлон шалтгаалжээ.

## 3. Урьдчилж төлсөн зардал, тооцоо

*(мянган төгрөгөөр)*

| ҮЗҮҮЛЭЛТ | 2023.12.31 | 2024.12.31 | Зөрүү |
|---|---|---|---|
| Урьдчилж төлсөн зардал | 330,399.6 | 321,380.9 | (9,018.7) |
| Урьдчилж төлсөн тооцоо | - | - | - |
| **Урьдчилж төлсөн зардлын дүн** | **330,399.6** | **330,399.6** | **(9,018.7)** |

Тайлант оны эцэст үлдэгдэл 9,018.7 мянган төгрөгөөр буурчээ.

## 4. Бараа материал

*(мянган төгрөгөөр)*

| Д/д | Бараа материалын төрөл | 2023.12.31 | 2024.12.31 | Өөрчлөлт |
|---|---|---|---|---|
| 1 | Бэлэн бүтээгдэхүүн | 191,010.6 | 191,010.6 | - |
| 2 | Дуусаагүй үйлдвэрлэл | 138,116.1 | 138,116.1 | - |
| | **Дүн** | **329,126.7** | **329,126.7** | - |

2024 оны 01 дүгээр сарын 01-с эхлэн компанийн үйл ажиллагааны үндсэн чиглэл болох нэхмэлийн үйлдвэрлэлийг харилцан хамаарал бүхий Капрадора кашмер ХХК-д шилжүүлсэн болович үйлдвэрлэлийн үйл ажиллагаатай холботой бэлэн бүтээгдэхүүн, дуусаагүй үйлдвэрлэлийн үлдэгдэл өөрчлөлт ороогүй, ТУЗ-с ямар нэгэн шийдвэр гаргаагүй байна.

## 5. Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгүүдийг түүхэн өртгөөр үнэлж, төрөл ба зориулалтаар нь ангилан нэрийн дансанд бүртгэж ашиглах хугацаанд шулуун шугамын аргаар элэгдүүлэн, дэлгэрэнгүй бүртгэлүүд ба тэнцэлд хөрөнгийн анхны өртөг ба хуримтлагдсан элэгдлийг зэрэгцүүлэн үзүүлсэн байна.

**Биет хөрөнгө** *(мянган төгрөгөөр)*

| Хөрөнгө | Анхны өртөг | | Хуримтлагдсан элэгдэл | | Үлдэгдэл өртөг | |
|---|---|---|---|---|---|---|
| | 12/31/2023 | 12/31/2024 | 12/31/2023 | 12/31/2024 | 12/31/2023 | 12/31/2024 |
| Барилга байгууламж | 616,442.2 | 616,442.2 | 135,198.6 | 171,691.3 | 481,243.6 | 444,750.9 |
| Барилга байгууламж-2 | 3,152,450.1 | 3,152,450.1 | 32,901.9 | 442,979.7 | 3,119,548.2 | 2,709,470.4 |
| Машин тоног төхөөрөмж | 490,488.3 | 490,488.3 | 281,595.8 | 343,074.8 | 208,892.5 | 147,413.5 |
| Тавилга эд хогшил | 192,026.4 | 192,571.8 | 65,152.0 | 102,672.7 | 126,874.4 | 89,899.1 |
| Компьютер дагалдах хэрэгсэл | 83,310.9 | 83,310.9 | 58,763.2 | 72,440.9 | 24,547.7 | 10,870.0 |
| Тээврийн хэрэгсэл | 309,323.6 | 309,323.6 | 281,491.6 | 300,339.8 | 27,832.0 | 8,983.8 |
| Бусад хөрөнгө | 557,964.4 | 557,964.4 | 57,476.7 | 115,110.9 | 500,487.7 | 442,853.5 |
| **ДҮН** | **5,402,005.9** | **5,402,551.3** | **912,579.8** | **1,548,310.1** | **4,489,426.1** | **3,854,241.2** |

**Биет бус хөрөнгө** *(мянган төгрөгөөр)*

| Хөрөнгө | Анхны өртөг | | Хуримтлагдсан элэгдэл | | Үлдэгдэл өртөг | |
|---|---|---|---|---|---|---|
| | 12/31/2023 | 12/31/2024 | 12/31/2023 | 12/31/2024 | 12/31/2023 | 12/31/2024 |
| Программ хангамж | 32,138.2 | 32,138.2 | 8,746.2 | 11,968.8 | 23,392.0 | 20,169.4 |
| **ДҮН** | **5,402,005.9** | **5,402,551.3** | **912,579.8** | **1,548,310.1** | **4,489,426.1** | **3,854,241.2** |

Тайлангийн жилд биет ба биет бус хөрөнгөнд нийт 638,952.9 мянган төгрөгийн элэгдэл байгуулсан ба үүнээс дахин үнэлгээ хийлгэсэн хөрөнгөнд тооцсон 410,077.8 мянган төгрөгийн элэгдлийг хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн дүнг бууруулан тооцож, үлдэх 228,875.0 мянган төгрөгийг удирдлагын зардалд бүртгэсэн байна.

Үйлдвэрлэлийн үйл ажиллагааг Капрадоро кашемир ХХК-д шилжүүлсэн байхад үйлдвэрлэлийн зориулалттай тоног төхөөрөмжид тооцсон 61,479.0 мянган төгрөгийн элэгдэл, борлуулалтын программ хангамжид тооцсон 3,222.6 мянган төгрөгийн хорогдуулалтыг удирдлагын зардлаар бүртгэсэн байна.

## 5. Өр төлбөр

Өр төлбөрийг нэрлэсэн үнэ цэнээр үнэлж, харилцагч байгууллага, хуулийн этгээд бүрээр данс нээж хөтлөн тайлангийн эхний ба эцсийн өдрөөрх өр төлбөрийг дараах дүнгээр илэрхийлж анхан шатны болон хураангуй бүртгэлүүдэд тусгасан байна. Үүнд:

*(мянган төгрөгөөр)*

| Төрлүүд | 2023.12.31 | 2024.12.31 | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Дансны өглөг | 1,087,791.4 | 276,149.1 | (811,642.3) |
| Цалингийн өглөг | 12,206.3 | 7,543.3 | (4,663.0) |
| ААНОАТ-ын өглөг | 12,281.7 | 24,172.8 | 11,891.1 |
| ХХОАТ-ын өглөг | 8,178.3 | 5,239.8 | (2,938.5) |
| НӨАТ-ын өглөг | 47,088.1 | 122,373.0 | 75,284.9 |
| Бусад татварын өглөг | 10,580.8 | 23,332.2 | 12,751.4 |
| НДШ-ийн өглөг | 8,437.6 | 5,042.8 | (3,394.8) |
| Богино хугацаат зээл | 224,631.6 | - | (224,631.6) |
| Урьдчилж орсон орлого | 78,842.6 | 58,979.9 | (19,862.7) |
| Урт хугацаат зээл | 1,125,000.0 | 728,750.0 | (396,250.0) |
| **Өр төлбөрийн дүн** | **2,615,038.4** | **1,251,582.9** | **(1,363,455.5)** |

Тайлант хугацаанд богино болон урт хугацаат зээл, харилцагч байгууллагад төлөх өглөгүүдийг төлж барагдуулсанаар өглөгийн үлдэгдэл нийт дүнгээрээ 1,363,455.5 мянган төгрөгөөр буурсан байна. Үүний дотор захиралд өгөх 748,611.6 мянган төгрөгийн өглөгийг авлагаас суутган тооцсон нь нийт буурсан дүнгийн 55.0 хувийг эзэлж байна.

## 6. Эзэмшигчийн өмч

*(мянган төгрөгөөр)*

| Д/д | Өмчийн төрөл | 2023.12.31 | 2024.12.31 | Өөрчлөлт |
|---|---|---|---|---|
| 1 | Хувьцаат капитал | 113,358.9 | 113,358.9 | - |
| 2 | Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл | 3,119,548.2 | 2,709,470.4 | (410,077.8) |
| 3 | Эздийн өмчийн бусад хэсэг | 79,080.9 | 79,080.9 | - |
| 4 | Хуримтлагдсан ашиг | 568,451.0 | 756,248.9 | 187,797.9 |
| | **Дүн** | **3,880,439.0** | **3,658,159.1** | **(222,279.9)** |

Тайланд онд эзэмшигчийн өмчийн дүн 222,279.9 мянган төгрөгөөр буурсан нь дахин үнэлгээ хийлгэсэн хөрөнгөнд тооцсон 410,077.8 мянган төгрөгийн элэгдлээр хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдлийн дүнг бууруулан тооцсонтой холбоотой байна.

## 7. Орлого, үр дүн

*(мянган төгрөгөөр)*

| ҮЗҮҮЛЭЛТ | 2023.12.31 | 2024.12.31 | Зөрүү |
|---|---|---|---|
| Борлуулалтын орлого | 859,708.3 | 8,638.7 | (851,069.6) |
| Түрээсийн орлого | 1,825,981.5 | 1,821,733.4 | (4,248.1) |
| **Үйл ажиллагааны орлогын дүн** | **2,685,689.8** | **1,830,372.1** | **(855,317.7)** |
| Борлуулсан бүтээгдэхүүний өртөг | 935,422.4 | - | (935,422.4) |
| Борлуулалт, маркетингийн зардал | 59,087.4 | 38,688.0 | (20,399.4) |
| Ерөнхий ба удирдлагын зардал | 1,632,803.9 | 1,429,842.6 | (202,961.3) |
| Санхүүгийн зардал | - | 90,325.2 | 90,325.2 |
| Бусад зардал | 90,239.4 | 59,545.6 | (30,693.8) |
| **Үйл ажиллагааны зардлын дүн** | **2,717,553.1** | **1,618,401.4** | **(1,099,151.7)** |

| | | | |
|---|---|---|---|
| **Тайлант үеийн цэвэр үр дүн** | **(31,863.3)** | **211,970.7** | **243,834.0** |

Өмнөх оноос нийт орлого 855,317.7 мянган төгрөгөөр, нийт зардал 1,099,151.7 мянган төгрөгөөр буурсан ба үүний дотор борлуулалтын орлого 851,069.6 мянган төгрөгөөр, борлуулсан бүтээгдэхүүний өртөг 935,422.4 мянган төгрөгөөр, борлуулалт маркетингийн зардал 20,399.4 мянган төгрөгөөр, ерөнхий ба удирдлагын зардал 202,961.3 мянган төгрөгөөр тус тус буурсан нь үйлдвэрлэлийг Капра доро кашемир ХХК-д шилжүүлсэнтэй холбоотой байна. Тайлант онд 211,970.7 мянган төгрөгийн татвар төлөхийн өмнөх ашигтай ажилласныг санхүүгийн тайланд тусгасан байна.

Үйлдвэрлэлийн үйл ажиллагааг өөр компанид шилжүүлсэн байхад тоног төхөөрөмж, борлуулалтын программ хангамжийн элэгдлийн 64,701.6 мянган төгрөгийн зардлыг удирдлагын зардлаар тайлагнасан байна. Түрээсийн орлого өмнөх онтой харьцуулахад өөрчлөлт багатай байна.

## 8. Ерөнхий ба удирдлага, борлуулалт маркетингийн зардал

*(мянган төгрөгөөр)*

| | ҮЗҮҮЛЭЛТ | Ерөнхий ба удирдлагын зардал | | Борлуулалт, маркетингийн зардал | |
|---|---|---|---|---|---|
| | | 2023.12.31 | 2024.12.31 | 2023.12.31 | 2024.12.31 |
| 1 | Үндсэн болон нэмэгдэл цалин | 112,375.8 | 266,635.2 | | |
| 2 | Нийгмийн даатгалын шимтгэл | 15,440.3 | 34,330.7 | | |
| 3 | Албан татвар, төлбөр, хураамжийн зардал | 46,856.9 | 74,120.4 | | |
| 4 | Даатгалын зардал | 2,841.5 | - | | |
| 5 | Мэргэжлийн үйлчилгээний зардал | 138,697.2 | 27,324.7 | 9,716.9 | |
| 6 | Албан томилолтын зардал | 9,356.3 | 982.2 | | |
| 7 | Элэгдлийн зардал | 198,244.4 | 228,875.0 | | |
| 8 | Түрээсийн зардал | 116,231.8 | | 25,690.7 | 1,709.1 |
| 9 | Ашиглалтын зардал | 648,605.0 | 638,422.1 | | |
| 10 | Харуул хамгаалалтын зардал | 4,371.8 | 1,588.7 | | |
| 11 | Засвар үйлчилгээний зардал | 221,820.7 | 122,468.2 | | |
| 12 | Цэвэрлэгээ үйлчилгээний зардал | 51,218.5 | | | |
| 13 | Бичиг хэргийн зардал | 29.4 | 50.8 | | |
| 14 | Шуудан холбооны зардал | 9,716.9 | | | 5,120.2 |
| 15 | Шатахууны зардал | 4,266.9 | 6,539.4 | | |
| 16 | Хүлээн авалтын зардал | | | 8,489.8 | 23,660.6 |
| 17 | Зар сурталчилгааны зардал | | | 15,190.0 | 8,198.1 |
| 18 | Тээврийн зардал | 16,383.7 | 22,382.8 | | |
| 19 | Хөдөлмөр хамгааллын зардал | 3,587.9 | 5,950.1 | | |
| 20 | Бусад зардал | 32,758.9 | 172.3 | | |
| | **Үйл ажиллагааны зардлын дүн** | **1,632,803.9** | **1,429,842.6** | **59,087.4** | **38,688.0** |

Тайлант онд ерөнхий ба удирдлагын зардал өмнөх оноос дүнгээрээ 12.0 хувиар буюу 202,961.3 мянган төгрөгөөр буурсаны дотор цалин хөлсний зардал 154,259.4 мянган төгрөгөөр нэмэгдэж, мэргэжлийн үйлчилгээ, засвар үйлчилгээ, цэвэрлэгээ үйлчилгээний зардлууд буурсан байна.

Аудитын явцад хамтран ажилласан ажилтнуудад талархал илэрхийлье.